

Ажлын байр цэвэрхэн байх нь зөвхөн “сайхан” харагдахад бус - харин аюулгүй ажиллагааг хангахад зориулагдсан.

2020 оны 01-р сар

Юу тохиолдсон бэ?

100 гаруй жил ашиглагдсан чихрийн тээрмийн ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээний дүрэм журам сул байсны улмаас төхөөрөмжийн эргэн тойронд болон тоноглолууд дээр чихэр наалдаж хуримтлагдсан байна. Улмаар хоолой бөглөрч, тоосон манан дэгдсэн нь галын эх үүсвэрүүдийг өдөөж, тэсрэлт болон гал гарах нөхцөл бүрджээ. Ослоор 14 хүн амиа алдаж, 38 хүн гэмтсэн ба үйлдвэр бүхэлдээ сүйрсэн байна.



Яагаад тохиолдсон бэ?

Чихэр бол шатамхай чанартай бөгөөд хэдийгээр амархан ноцдоггүй ч тэсрэлт үүссэн тохиолдолд их хэмжээний энерги ялгаруулж ноцтой тэсрэлт, гал дэгдээх хүчтэй.

Анх тэсрэлт үүссэний дараа боловсруулах хэсэгт хуримтлагдаж үлдсэн байсан чихэр нэмэлт тэсрэлтүүдийг өдөөсөн аж. Эхний тэсрэлт ноцтой байсан хэдий ч чихэр хадгалагдсан байсан нь дараачийн тэсрэлт болон галыг өдөөж, үр дагаврыг асар ихээр нэмэгдүүлжээ.

Тус үйлдвэрт ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээний журам бүрэн мөрдөгддөггүй байсан бөгөөд олон жилийн хугацаанд хэд хэдэн гал гарсан нь мэдээлэгдэж байсан боловч залруулах арга хэмжээ хангалтгүй, урт хугацаанд үйлчилдэггүй байсан байна. (Ref CSB Investigation -Imperial Sugar Fire & Explosion 02/07/2008 report 2008-05-I-GA-6 - 09/24/2009)

Та мэдэх үү?

- Боловсруулалтын процессоос хуримтлагдаж үлдсэн бодис, савлагаанд ашиглагддаг материалууд (хуванцар, цаас/картон, мод гэх мэт) гал болон тэсрэлт үүссэн үед ноцоох хэрэгсэл болдог. Үүнээс сэргийлэхэд ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээ зайлшгүй чухал юм.
- Аюулгүйн систем (галын хамгаалалт гэх мэт) нь тоос, асгарсан материал зэрэг дагалдах ноцоогч хэрэгслүүдээс хамгаалахад зориулагдаагүй байж болно.
- Асгарч гоожсон түүхий материал, боловсруулалтын бодис, эцсийн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлд алдагдал үүсгэдэг.
- Ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээнд зөвхөн асгарсан материал цэвэрлэх ажил багтахгүй. Ашиглагдаагүй багаж, сав баглааг зөв цэгцэлж хадгалах зэрэг ажил мөн багтдаг.
- Тоос шороо, нунтаг материалд агуулагдах металлууд тэсрэлт, галын аюул үүсгэх боломжтой. Тэдгээрт бусад шатамхай материалын адил болгоомжтой хандах хэрэгтэй.

Та юу хийж чадах вэ?

- Өөрийн ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээний шаардлагуудыг мэддэг, мөрддөг байх хэрэгтэй.
- Ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээний ажил хийх үед цугларсан материалуудыг зөөх, хаяхад зөв арга техник ашигла.
- Металл хаягдал онцгой аюултай бөгөөд хаях тусгай арга техник шаарддаг тул тэдгээрийг олж мэдэх, мөрдөх хэрэгтэй.
- Материалын эх үүсвэр тодорхой бус бол цэвэрлэгээнд тохирох ХХХ-ийн талаар аюулгүй ажиллагааны ажилтнаас зөвлөмж ав.
- Ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээний стандартад нийцэхгүй зүйлийг ажиглаж, ахлах ажилтандаа мэдээл. Мөн даруй зөв, аюулгүй арга техник ашиглан цэвэрлэх нь зүйтэй.

Ажлын талбай цэвэрхэн байснаар аюулаас сэргийлнэ!

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE –с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Бидэнтэй ccps_beacon@aiiche.org эсвэл 646-495-1371 хаягаар холбогдоно уу.

Beacon –Үйлдвэрлэлийн Аюулгүй Ажиллагааны Сануулга ихэвчлэн Африк, Араб, Катар, Хятад, Чех, Дани, Голланд, Англи, Филиппин, Франц, Герман, Грек, Гуэжарати, Еврей, Хинди, Индонези, Итали, Япон, Солонгос, Малай, Марати, Монгол, Перси, Польш, Португали, Роман, Орос, Испани, Швед, Тэлугу, Тайланд, Турк болон Вьетнам хэл дээр гарсан байна.